# ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБАНЫ АХЛАГЧ БҮРЭЛДЭХҮҮНИЙ АЛБАНЫ СУРГАЛТЫГ ЧАНАРЖУУЛАХ, ҮР ДҮНГ ДЭЭШЛҮҮЛЭХ АСУУДАЛ

О.Батбилэг
Дотоод хэргийн их сургуулийн
Ахлагчийн сургуулийн Онцгой байдлын албаны тэнхимийн эрхлэгч,
дэд хурандаа

***Товч агуулга:*** Онцгой байдлын албаны ахлагч бүрэлдэхүүний сургалтыг чанаржуулах, төлөвлөгөө хөтөлбөрийн агуулга, сургалтын хэлбэр болон сургалтын материаллаг орчин, хүртээмж, үр өгөөжийн байдалд зохих судалгааг хийж судалгааны үр дүнгээс танилцуулж байна.

***Түлхүүр үгс:*** Сургалтын бүсчилсэн төв, хөтөлбөр, сургалтын хэлбэр

## ОРШИЛ

Манай оронд обьектын болон ой хээрийн түймэр, ган, зуд, цасан болон шороон шуурга, цөлжилт, хэт халалт зэрэг байгалийн гамшгаас гадна хүн, мал, амьтны гоц халдварт өвчин, хортон шавьжны тархалт, үйлдвэр, тээврийн хэрэгслийн осол, цацраг идэвхт хордолт, химийн хорт бодисын алдагдалт зэргээс хүний амь эрсдэх, улс орны нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжил, хүрээлэн буй орчинд ихээхэн хохирол учирсаар байна.

Сүүлийн жилүүдэд гамшгаас хамгаалах, гамшгийн аюулыг бууруулах талаар нэлээд арга хэмжээнүүдийг авч байна.

Манай улсад гамшгийн аюулыг бууруулахад чиглэгдсэн арга хэмжээг улс орныхоо хэрэгцээ шаардлага, олон улсын жишигт нийцүүлж шинэчлэн үндэсний чадавхийг дээшлүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Олон улсын туршлагаас үзвэл, гамшиг, гал түймэр, аюулт үзэгдэл тохиолдсон үед эрэн хайх, авран туслах багийн бүрэлдэхүүн очихоос өмнө орон нутгийн иргэд нь нэрвэгдэгсдийн 30 орчим хувийг буюу гамшигт багаахан гэмтэл авсан, хөнгөн нэрвэгдэгсдийг аврах үйл ажиллагааг гүйцэтгэсэн байдаг.

Харин үлдсэн хэсгийг буюу тухайлбал нурангийн гүнд дарагдсан болон олон зуун нэрвзгдэгсдийг тусгай хүчжүүлсэн мэргэжлийн бүрэлдэхүүн гүйцэтгэдэг болох нь судалгаанаас харагддаг. Ийм учраас гамшгийн үед ажиллах мэргэжлийн аврагч нарыг бэлтгэх нь чухал ач холбогдолтой боллоо.

Онцгой байдлын албанд нийт 3000 шахам аврагч ажиллаж байна. Үүнээс 45,5 хувь нь гал сөнөөгч 30,0 хувь нь аврагч-жолооч 24,5 хувь нь төрөл мэргэжлийн аврагч эзэлж байна. БХИС-ийн Ахлагчийн сургуульд 1996 оноос эхлэн гамшгаас хамгаалах төрөл мэргэжлийн гал сөнөөгч-шүхэрчин, холбоочин, усчин аврагч, химичин, инженерийн аврагч нарыг эхлэн бэлтгэж ирсэн байна.

2008 оноос ОБЕГ-ын харъяа Аврах тусгай ангид, 2011 оноос ОБЕГ-ын харъяа Тусгай мэргэжлийн сургалтын төв шинээр байгуулагдан мэргэжлийн аврагч, аврагч-гал сөнөөгч, дуудлага хүлээн авагч нарыг тус тус бэлтгэж байгаад 2013 оноос ХСИС-ийн харьяа Ахлагчийн сургуульд 4 сарын хугацаатайгаар Онцгой байдлын албаны “Аврагч-гал сөнөөгч, аврагч- жолооч” нарыг бэлтгэж байна.

**Нэг. Сургалтын өнөөгийн байдал:** Онцгой байдлын албаны албан хаагчдынхаа мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, сургалтын арга хэлбэрийг сайжруулах зорилгоор Хууль сахиулахын их сургуулийг түшиглэн Онцгой байдлын салбарын чиглэлийн 8 мэргэжлээр албан хаагч бэлтгэдэг болох, мэргэшүүлэх, гадаадад сургах албан хаагчийн тоог нэмэгдүүлэх чиглэлээр олон ажлуудыг хэрэгжүүлж байна.

ОБЕГ-ын харьяа Аврах тусгай ангийг түшиглэн ахлагч нарыг мэргэшлийн байдлаар сургалтыг зохион байгуулж байна. Инженерийн чиглэлийн мэргэжлээр БХИС-д нэг сарын хугацаатайгаар бэлтгэж байна.

Хууль сахиулахын их сургуульд дээд боловсролтой гамшгаас хамгаалах мэргэжилтэн, Ахлагчийн сургуульд аврагч нарыг бэлтгэж байгаагаас гадна, Аврах тусгай ангийн дэргэд Мэргэжил дээшлүүлэх давтан сургалтын төв ажиллаж байна.

Мөн төрөл бүрийн аврагч нарыг аймаг орон нутагт чиглэлээр нь богино хугацаатай сургаж байна.

Гамшгаас хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд техник технологи, багаж хэрэгслийг шинэчлэхээс гадна бие бүрэлдэхүүний гамшгаас хамгаалах системтэй сургалт, дадлагыг тасралтгүй явуулж, боловсон хүчний мэдлэг, ур чадварыг дээшлүүлж, олон улсын түвшинд хүргэх нь хамгаас чухал юм.

Аврах анги, салбарт явагдаж буй сургалт, бэлтгэл өнөөгийн шаардлагыг төдийлөн хангахгүй байна. Мөн мэргэжлийн аврагч нарыг бэлтгэх, түүний тогтолцоо, сургалтын агуулга, арга зүй, боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Олон улсын хэмжээнд Онцгой байдлын мэргэжилтэнг гүйцэтгэх үүрэг, зохицсон чадамж эзэмшүүлэх, аврагч мэргэжлийг эрчимтэй, мэдээлэлжсэн технологиор богино хугацаанд чанартай суурь боловсрол олгохын зэрэгцээ Онцгой байдлын албаны ахлагч бүрэлдэхүүний мэдлэгийг гүйцэтгэх үүргийнх нь хэмжээнд эзэмшүүлэхэд анхаарах болжээ.

Судалгаанаас үзэхэд хөдөө орон нутагт байрлах аврах салбарын захирагч нар нь бүлэг, салаа, салбарын түвшинд боловсрол эзэмшсэн байгаа нь аюул осол, байгалын гамшиг тохиолдсон үед тухайн салбарыг өргөтгөн зохион байгуулахад бэлтгэгдээгүй байгаа зэргээс харагдаж байна.

Дээрх байдлаас үзвэл, мэргэжлийн аврагч нарыг бэлтгэх, түүний тогтолцоо, сургалтын агуулга, арга зүй, боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагчдын 2012-2013 оны хичээлийн жилийн албаны сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө нь ОБЕГ-ын даргын А/726 тоот тушаалаар батлагдан эхэлж байсан агуулга, цаг сэдвийн төлөвлөгөө орон нутгийн Онцгой байдлын албаны ахлагч бүрэлдэхүүний сургалт одоог хүртэл нэгэн хэв загвараар явагдаж байна.

Энэхүү сургалтын хөтөлбөрт судалгаа хийж үзэхэд тэнхимийн сургалтын цаг нь их, дадлага-сургалтын цаг нь багаар тавигдсан нь харагдаж байна. Ахлагч бүрэлдэхүүний сургалтын онолын цаг нь их тавигдснаар сургалт чанаргүй явагдаж байна. Харин дадлага- сургалтын цаг нь илүү тавигдснаар ахлагч бүрэлдэхүүний сургалтын чанарт ахиц гарна гэж үзэж байна.

Аврагчдын сургалт бэлтгэлийн мөн чанар нь сургалтын зорилго, зорилтууд, агуулга стандарт, арга технологи, тэдгээрийн үр дүнд бүтээгдэх дадлага сургалтын жигдрэлт, аврах ажиллагааны ур чадвараар илэрч байгаа нь практикаас харагддаг.

**Хоёр: Зарим улс орнуудын аврагч бэлтгэж буй байдлыг өөрийн орны байдалтай харьцуулсан судалгаа**

Аврагч гэдэг бол мэргэжлийн зохих бэлтгэлийг хангасан эрэн хайх, аврах ажлыг гүйцэтгэгч албан тушаалтан. Тэд эх орныхоо төлөө өөрийн амь биеэ зориулж чадах зоригтон байдаг. Өөрийн амь биеийг золиослон байж, иргэдийн амь насыг аврахад суралцах явдал бол хүнд хөдөлмөрийн нэг гэж дэлхий нийтээр хүлээн зөвшөөрсөн байдаг. Тийм ч учраас дэлхийн хамгийн хүнд 5 мэргэжилд аврагч нарыг оруулсан байдаг.

Манай оронд бэлтгэж буй аврагч нь ОХУ-д бэлтгэж буй аврагч нарын төрөл, мэргэжилтэй ойролцоо байна.

Харин АНУ-д бэлтгэж буй аврагч нар нь нэлээд нарийн гүнзгийрүүлсэн байдалтай бэлтгэж байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Дээрх байдлаас дүгнэлт хийж үзвэл, ОХУ-д 10, АНУ-д 16, манай оронд бэлтгэж буй аврагч нарт 11 төрлийн хичээл үзэж байгаа нь дундаж түвшинд байна.

**Гурав. Ахлагч бүрэлдэхүүний албаны сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсронгүй болгох.**

Хүний амь аврах сургалт бол аврагч хүний үндсэн хөдөлмөр бөгөөд хүний амь нас, эд хөрөнгийг аврах бэлэн байдлыг хангах үндэс юм.

Аврагчдын сургалт бэлтгэлийн мөн чанар нь сургалтын зорилго, зорилтууд, агуулга стандарт, арга технологи, тэдгээрийн үр дүнд бүтээгдэх дадлага сургалтын жигдрэлт, аврах ажиллагааны ур чадвараар илэрхийлэгдэнэ.

Аврагчдын сургалт бэлтгэлийн зорилго нь Онцгой байдлын албаны аврах ажиллагааны болон энхийг сахиулах үүрэг гүйцэтгэх бэлтгэл, жигдрэлтийг хангахад оршино.

Аврагчдын сургалт бэлтгэл нь Онцгой байдлын албан хаагчдад иргэдээ хамгаалахад шаардагдах, мэдлэг, чадвар, дадал болон эх оронч үзэл, хүмүүжил олгон улмаар бие бялдар, сэтгэл зүйн хат суулгах зорилготой сурган хүмүүжүүлэх ухааны нэг салбар ухаан бөгөөд даргалах (байнгын) бүрэлдэхүүнд аврах ажиллагааны тухайн шатны боловсрол олгох, иргэдэд аврах анхан шатны мэдлэг, дадлага эзэмшүүлэхэд чиглэгдэнэ.

Аврагч нарын сургалт нь анхан шатны, төрөл мэргэжлийн, давтан сургалт гэсэн ангиллаар явагдаж байна. Орон нутгийн ахлагч бүрэлдэхүүнд явагдаж буй сургалтад дүн шинжилгээ хийж, аврагчдын сургалтын нэгдсэн тогтолцооны загварыг зөвлөмж болгож байна.

Дээрх байдлаас үзвэл, Онцгой байдлын албаны ахлагч бүрэлдэхүүний албаны сургалтын чадамжийг сайжруулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

ОБЕГ-ын харьяа Аврах тусгай ангийн Мэргэжил дээшлүүлэх давтан сургалтын төвд ахлагч нарыг мэргэшлийн байдлаар сургалтыг зохион байгуулж байна. Инженерийн чиглэлийн мэргэжилээр БХИС-д 1 сарын хугацаатайгаар

бэлтгэж байна. Мөн БНСУ, ОХУ, Хятадад зарим чиглэлээр аврагч нарыг мэргэжлийн бэлтгэл сургалтад хамруулж байна.

Дээрх судалгаанаас харахад Аврах тусгай ангийн давтан сургалтын төвд сүүлийн хоёр жилд аврагч 28, аврагчхолбоочин 29, аврагч-усчин 10, багны засварчин-техникч 44, шүхэрчин-нисэх төхөөрөмжийн нисгэгч 7 нийт 118 албан хаагчийг хамруулж мэргэшүүлсэн байна.

**Дүгнэлт:**

1. Онцгой байдлын албаны ахлагч бүрэлдэхүүний албаны сургалтын хөтөлбөрт дүн шинжилгээ хийхэд сүүлийн 3 жилийн байдлаар лекц, семинар, дадлага явуулах цагийн тооцоо 21 аймагт адил явагддаг. Дээрх судалгаанаас харахад хөдөө орон нутагт байрлах Онцгой байдлын газруудын Гал унтраах аврах анги, Эрэн хайх, аврах анги, салбарын ахлагч бүрэлдэхүүний сургалт явуулахад дараах хүндрэл бэрхшээл тулгарч байдаг.

Үүнд: -Заагдах тэнхимын хичээлийн цаг нь их, дадлага хичээлийн цаг нь бага -Хамрагдах хүний тоо их -Сургалт явуулах багшийн бэлтгэл хангалтгүй /ажлын байрны тодорхойлолтод тусгасан ажил үүрэгээ гүйцэтгэхтэй холбоотой, ачаалал их/ -Сургалт явуулах багшийн хичээл заах иж бүрдэл дутагдалтай /хичээлийн конспект, цаг сэдвийн төлөвлөгөө г.м/ -Сургалтын хэрэглэгдэхүүн дутагдалтай. /санхүүжилтэй холбоотойгоор сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулахад хүндрэлтэй /Заах арга зүй, чадвар хангалтгүй Анги танхим, материаллаг бааз дутагдалтай /ширээ, сандал хүрэлцээгүй/ гэх мэт.

2.Онцгой байдлын байгууллагын албан хаагчдын албаны сургалтыг зохион байгуулахдаа орон нутгийн Онцгой байдлын газрууд сургалтын хөтөлбөрийн ашиглахыг зөвлөж байна.

3.Орон нутгийн Онцгой байдлын газрууд сургалтын материаллаг баазтай, багшлах хүний нөөц, багш нарыг эрдэмжүүлэх чиглэлээр цаашид анхаарч ажиллах хэрэгтэй.

4.Монгол Улсын хэмжээнд тохиолдсон гамшгийн сүүлийн 5 жилийн судалгаанаас бүсчилэн үзэхэд хамгийн их тал хээрийн түймэр зүүн бүсийн аймгуудад, хүчтэй салхи шуурга төвийн бүсийн аймгуудад, үерийн аюул баруун бүсийн аймгуудад, усанд осолдсон болон ойн түймэр, объектын гал түймэр хойд бүсийн аймгуудад зонхилон тус тус гарсан байна.

Үүнд дүгнэлт хийхэд дээрх бүсийн аймгуудад тохиолдсон гамшгийн төрлүүдээр нь бүсчилсэн сургалтын төв байгуулж, аймаг орон нутгуудаас 5-10 аврагч нарыг тусгайлан бэлтгэж мэргэшүүлэн, сургагч багш бэлтгэснээр тухайн багш нар нь орон нутагтаа аврагч нарын сургалтыг чанартай зохион явуулах боломжтой. Мөн аймгуудад зонхилон тохиолддог гамшгийн төрлүүдээс нь хамааран сургалтуудыг төрөлжүүлэн явуулах нь зүйтэй гэж үзэж байна.

**Санал**

1.Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу хөдөө, орон нутагт ахлагч бүрэлдэхүүний албаны сургалтыг зохион явуулахад хичээлийн хөтөлбөр, төлөвлөгөө, цаг сэдвийн тооцоог боловсруулан явуулбал сургалтын хүртээмж дээшлэнэ.

2.Орон нутгийн бүсийн төвүүдийг түшиглэн бүсчилсэн сургалтын төв байгуулахтай холбогдуулан Олон улсын хандив, төсөл хөтөлбөрийн санхүүжилтийн хөрөнгө оруулалтыг энэ чиглэлд хандуулах, сургалтын материаллаг бааз, техник, тоног төхөөрөмжийг сургалтын стандарт, орчин үеийн шаардлагад нийцүүлэн бүрдүүлэх.

**Эх сурвалжийн жагсаалт**


- Гамшгаас хамгаалах хууль тогтоомжийн эмхтгэл. УБ.2008 он
- ОБЕГазрын гамшгийн судалгаа
- Улсын хил хамгаалалтанд тулгамдаж буй асуудал /эрдэм шинжилгээний онолын бага хурлын эмхэтгэл/.УБ.2013 он
- Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь
- Дамдин.П. Үндэсний аюулгүй байдалд байгалийн гамшгийн үзүүлэх нөлөөг бууруулах арга зам. УБ.2013 он